# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГСА-2024/02/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Говьсүмбэр аймаг<br>2024 он | Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br>Утас: 70543179<br>Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn<br>Аудитын менежер: Г.Наранбаяр<br>Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn<br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн:<br>Баталгаат тооцоолол аудитХХК-ийн<br>Захирал: М.Буянбулган<br>Утас: 77153069<br>Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com<br>Чанарын менежер: Г.Цогтбаатар<br>Аудитор: Н.Цэнгэнбаяр |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 2
**Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
**Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 11
**5.1 Төлбөрийн акт** ..... 11
**5.2 Албан шаардлага** ..... 11
**5.3 Зөвлөмж** ..... 13
**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 13
**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл** ..... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ГСА | Говьсүмбэр аймаг |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| ӨХЗ | Өмч хамгаалах зөвлөл |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

## Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2024.02.23 № 45

танай ____________-ны № ____________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Ц.МӨНХ-ОД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020317

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 111 арга хэмжээг хэрэгжүүлж 98.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасныг аймгийн Засаг дарга 92.9 хувийн биелэлттэйгээр дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

# Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **183,340,005.25** | **168,524,862.23** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 7,215,174.71 | 6,872,174.71 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **7,215,174.71** | **6,872,174.71** |
| 31217 | Нөөц харилцах ахмад | 7,215,174.71 | 6,872,174.71 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **176,124,830.54** | **161,652,687.52** |
| **351** | **Түүхий эд материал** | **127,017,122.79** | **115,453,628.29** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 34,703,455.34 | 37,939,025.34 |
| 35130 | Эм боох материал | 92,313,667.45 | 77,514,602.95 |
| **354** | **Хангамжийн материал** | **49,107,707.75** | **46,199,059.23** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,579,100.00 | 3,265,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,470,020.00 | 12,776,120.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,839,210.00 | 1,520,130.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 27,219,377.75 | 28,637,709.23 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **724,701,745.65** | **753,268,032.37** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 724,701,745.65 | 753,268,032.37 |
| **392** | **Биет хөрөнгө** | **724,701,745.65** | **753,268,032.37** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 625,232,190.83 | 674,734,668.83 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (25,027,933.79) | (55,054,648.55) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 84,000,000.00 | 84,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (45,500,000.13) | (59,500,000.17) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 112,944,798.10 | 142,652,484.10 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (39,646,066.40) | (55,632,972.98) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 48,574,486.49 | 53,311,518.49 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (35,875,729.45) | (31,243,017.35) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **0.00** | **0.00** |
| 39301 | Програм хангамж | 800,000.00 | 800,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (800,000.00) | (800,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **908,041,750.90** | **921,792,894.60** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **1,350,000.00** |
| **413** | **Өглөг** | 0.00 | 1,350,000.00 |
| 4136 | Бусад өглөг | 0.00 | 1,350,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 908,041,750.90 | 920,442,894.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 121,195,354.07 | 121,195,354.07 |
|  | Дахин үнэлгээний нөөц | 39,202,306.24 | 39,202,306.24 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 747,644,090.59 | 760,045,234.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 747,644,090.59 | 747,644,090.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 12,401,143.70 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **908,041,750.90** | **921,792,894.60** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,321,638,155.50** | **1,373,625,338.77** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,047,436,071.50** | **331,960,600.02** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | **4,519,028.00** | **92,211,764.00** |
| 120009 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | **1,042,917,043.50** | **239,748,836.02** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 70,468,684.00 | 42,832,665.75 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 17,387,000.00 | 6,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 53,081,684.00 | 36,832,665.75 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 1,203,733,400.00 | 998,832,073.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,203,733,400.00 | 998,832,073.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,338,800,576.57** | **1,139,116,206.03** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,338,800,576.57** | **1,139,116,206.03** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 261,030,729.80 | 445,455,695.63 |
| 210101 | Үндсэн цалин | 189,902,602.80 | 297,598,800.39 |
| 210102 | Нэмэгдэл | 37,194,820.00 | 83,711,164.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,060,000.00 | 20,365,000.00 |
| 210104 | Урамшуулал | 16,873,307.00 | 43,780,730.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,496,126.00** | **54,421,345.59** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,601,958.53 | 38,229,394.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,626,273.23 | 4,497,575.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,013,658.57 | 3,514,460.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 469,703.95 | 736,720.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,784,531.72 | 7,443,194.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **52,749,382.35** | **55,297,895.51** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,737,366.35 | 2,644,069.71 |
| 210302 | Түлш, халаалт | 48,846,100.00 | 50,305,458.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,165,916.00 | 2,348,367.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **52,727,355.50** | **66,015,172.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,377,700.00 | 4,579,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,178,650.00 | 11,289,080.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,768,171.00 | 2,104,082.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 425,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,047,055.00 | 1,625,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 24,175,779.50 | 45,991,810.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **310,031.49** | **0.00** |
| 210502 | Хоол, хүнс | 310,031.49 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **82,421,712.00** | **14,194,725.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 999,229.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 81,422,483.00 | 14,194,725.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,668,000.00** | **2,827,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,668,000.00 | 2,827,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,711,950.00** | **10,103,940.60** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,703,000.00 | 5,088,250.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,800,000.00 | 1,872,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,200,000.00 | 735,075.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68,466.00 | 72,366.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 18,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,896,000.00 | 2,318,149.60 |
| 210807 | Газрын төлбөр | 22,484.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **105,526,592.58** | **103,474,981.28** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,869,900.00 | 33,857,804.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,731,050.00 | 1,182,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 48,925,642.58 | 68,434,377.28 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **591,664,691.00** | **259,264,521.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 49,941,400.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 341,912,399.00 | 67,734,801.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 197,420,892.00 | 190,179,720.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,390,000.00 | 1,350,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **139,494,005.85** | **128,060,329.42** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 139,494,005.85 | 128,060,329.42 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **982,837,578.93** | **234,509,132.74** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,008,589,994.79** | **222,107,989.04** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 1,008,589,994.79 | 222,107,989.04 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (25,752,415.86) | 12,401,143.70 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(25,752,415.86)** | **12,401,143.70** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,279,202,084.00** | **1,041,664,738.75** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **8,000,000.00** | **0.00** |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,000,000.00 | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **67,468,684.00** | **42,832,665.75** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 9,387,000.00 | 6,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 58,081,684.00 | 36,832,665.75 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **1,203,733,400.00** | **998,832,073.00** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,203,733,400.00 | 998,832,073.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,267,596,414.00** | **1,037,218,838.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,267,596,414.00** | **1,037,218,838.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 261,030,729.80 | 445,455,695.63 |
| 210101 | Үндсэн цалин | 187,621,544.00 | 297,673,061.39 |
| 210102 | Нэмэгдэл | 37,194,820.00 | 84,159,259.05 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,060,000.00 | 20,434,997.48 |
| 210104 | Урамшуулал | 19,154,365.80 | 43,188,377.71 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,496,126.00** | **54,421,345.59** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,601,958.53 | 38,229,394.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,626,273.23 | 4,497,575.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,013,658.57 | 3,514,460.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 469,703.95 | 736,720.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,784,531.72 | 7,443,194.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **52,749,382.35** | **55,297,895.51** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,737,366.35 | 2,644,069.71 |
| 210302 | Түлш, халаалт | 48,846,100.00 | 50,305,458.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,165,916.00 | 2,348,367.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,165,566.00** | **21,729,282.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,153,800.00 | 4,133,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,764,320.00 | 10,970,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,768,171.00 | 2,104,082.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 425,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,299,275.00 | 4,096,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **82,705,883.00** | **15,099,725.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 605,000.00 | 0.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 678,400.00 | 905,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 81,422,483.00 | 14,194,725.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,668,000.00** | **2,827,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,668,000.00 | 2,827,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,877,050.00** | **10,103,940.60** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,643,600.00 | 5,088,250.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,800,000.00 | 1,872,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,200,000.00 | 735,075.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68,466.00 | 72,366.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 18,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,120,500.00 | 2,318,149.60 |
| 210807 | Газрын төлбөр | 22,484.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **56,744,980.00** | **46,308,504.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,693,900.00 | 45,125,704.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 32,051,080.00 | 1,182,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **596,664,691.00** | **257,914,521.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 49,941,400.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 341,912,399.00 | 67,734,801.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 197,420,892.00 | 190,179,720.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,390,000.00 | 0.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **139,494,005.85** | **128,060,329.42** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 139,494,005.85 | 128,060,329.42 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **6,304,000.00** | **4,788,900.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,304,000.00 | 4,788,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **11,605,670.00** | **4,445,900.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 5,301,670.00 | (343,000.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 1,913,474.71 | 7,215,174.71 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 7,215,144.71 | 6,872,174.71 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 121,195,354.07 | 39,202,306.24 | 747,644,090.59 | 908,041,750.90 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 121,195,354.07 | 39,202,306.24 | 747,644,090.59 | 908,041,750.90 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 121,195,354.07 | 39,202,306.24 | 747,644,090.59 | 908,041,750.90 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 12,401,143.70 | 12,401,143.70 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 121,195,354.07 | 39,202,306.24 | 760,045,234.29 | 920,442,894.60 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Хувь |
|---|---|---|---|---|
| 2 | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,000,276,900.00** | **870,771,743.58** | 87.1 |
| 210 | **Бараа, үйлчилгээний зардал** | **740,164,000.00** | **612,857,222.58** | 82.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 551,973,600.00 | 441,078,874.63 | 79.9 |
| 210101 | Үндсэн цалин | 312,836,700.00 | 297,673,061.39 | 95.2 |
| 210102 | Нэмэгдэл | 170,476,700.00 | 79,782,438.05 | 46.8 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 29,898,000.00 | 20,434,997.48 | 68.3 |
| 210104 | Урамшуулал | 38,762,200.00 | 43,188,377.71 | 111.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **68,996,600.00** | **53,887,304.84** | 78.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,917,700.00 | 37,857,364.66 | 80.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,519,700.00 | 4,453,807.47 | 80.7 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 4,415,800.00 | 3,479,446.01 | 78.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,103,900.00 | 729,153.87 | 66.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,039,500.00 | 7,367,532.83 | 66.7 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **55,398,600.00** | **55,297,895.51** | 99.8 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 2,741,000.00 | 2,644,069.71 | 96.5 |
| 210302 | Түлш, халаалт | 50,309,200.00 | 50,305,458.60 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,348,400.00 | 2,348,367.20 | 100.0 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **22,376,300.00** | **22,319,282.00** | 99.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,135,200.00 | 4,133,900.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 10,972,600.00 | 10,970,000.00 | 100.0 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 2,109,400.00 | 2,104,082.00 | 99.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 467,200.00 | 425,000.00 | 91.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 4,691,900.00 | 4,686,300.00 | 99.9 |
| 2106 | **Эд хогшил худалдан авах** | **19,394,100.00** | **19,298,625.00** | 99.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,268,000.00 | 4,198,900.00 | 98.4 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 911,100.00 | 905,000.00 | 99.3 |
| 210604 | Урсгал засвар | 14,215,000.00 | 14,194,725.00 | 99.9 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **3,649,800.00** | **2,827,600.00** | 77.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,649,800.00 | 2,827,600.00 | 77.5 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **10,229,200.00** | **10,103,940.60** | 98.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,204,400.00 | 5,088,250.00 | 97.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,872,000.00 | 1,872,000.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 735,100.00 | 735,075.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 77,600.00 | 72,366.00 | 93.3 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 18,100.00 | 18,100.00 | 100.0 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 2,322,000.00 | 2,318,149.60 | 99.8 |
| 2201 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,145,800.00** | **8,043,700.00** | 98.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,958,400.00 | 6,860,900.00 | 98.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,187,400.00 | 1,182,800.00 | 99.6 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **260,112,900.00** | **257,914,521.00** | 99.2 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 67,744,400.00 | 67,734,801.00 | 100.0 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 190,985,600.00 | 190,179,720.00 | 99.6 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,382,900.00 | | - |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,000,276,900.00** | **998,832,073.00** | 99.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,000,276,900.00 | 998,832,073.00 | 99.9 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |

| | | |
|---|---|---|
| 2 | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **36,832,665.75** |
| 210 | **Бараа, үйлчилгээний зардал** | **36,832,665.75** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,376,821.00** |
| 210102 | Нэмэгдэл | 4,376,821.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **534,040.75** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 372,029.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 43,768.21 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 35,014.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,566.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 75,661.93 |
| 2201 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **31,921,804.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,921,804.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **36,832,665.75** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36,832,665.75 |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,452.7 мянган төгрөгийн 4 зөрчил[1] илэрсэн бөгөөд зөрчлийг арилгах 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Албан хаагчдын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон болович Эрүүл мэндийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/226 дугаартай тушаалыг үндэслэн нягтлан бодогч Д.Баярболд, мэргэжилтэн Д.Батчимэгт 2022 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан "Өөрчлөлтгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр Газрын даргын тушаалгүйгээр урамшуулалд нийт 3,452,862.00 төгрөг тооцож урамшуулал давхардуулан олгосон.

Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 “төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах”, 7.1.6 “албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх”,7.1.7“албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 40.3 дэх "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ", Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх “ Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.", Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалтыг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Байгууллагын удирдлагын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалыг тухай бүр олгосон болович тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, санхүүгийн зөрчилгүй ажиллах үүрэгтэй төсвийн шууд захирагчид Эрүүл мэндийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/226 дугаар тушаалыг үндэслэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Өөрчлөлтгүй"

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дүгнүүлсэн гэх үндэслэлээр газрын даргад 2,177,314.0 төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон ба сайдын тушаал нь хүчингүй болсон журам үндэслэсэн.

Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 “төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах”, 7.1.6 “албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх”,7.1.7“албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 40.3 дэх "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ", Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх “ Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.", Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалтыг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Холбогдох хууль, эрх зүйн актуудын заалттай нийцсэн шийдвэрийг мөрдөж ажиллах, түүнд тавих хяналтыг сайжруулахыг шаардаж байна.

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын ажилтанд ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалыг тухай бүр олгосон боловч Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 543 тоотыг үндэслэн Эрүүл мэндийн газрын даргын Б/25 дугаар тушаалаар Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтэн, статистикч эмч Б.Наранцэцэгт 3 сараар үндсэн цалингийн 40 хувиар тооцож 1,121,878.00 төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон . бөгөөд уг шийдвэр нь төсвийн захирагчид эрх олгох эрх бүхий албан тушаалтан биш, мөн хүчингүй болсон тушаал, журам үндэслэсэн хүчин төгөлдөр бус шийдвэрээр олгосон.

Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 “төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах”, 7.1.6 “албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх”,7.1.7“албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 40.3 дэх "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ", Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх “ Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.", Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалтыг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Холбогдох хууль, эрх зүйн актуудын заалттай нийцсэн шийдвэрийг мөрдөж ажиллах, түүнд тавих хяналтыг сайжруулахыг шаардаж байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Бараа материалын тайлан, анхан шатны баримтуудтай танилцахад агуулахын бүртгэл хөтөлдөггүй, зарим баримтын гарын үсгийн баталгаажуулалт дутуу, жолоочийн тооцооны хуудсыг 5-9 сард тухай бүрт холбогдох зааврын дагуу бүрэн хөтөлж, тооцоог хийгээгүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлсан журмын тухайн маягтуудыг хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих заавρыг мөрдлөг болгоогүйтэй холбоотой байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байн.

Өгсөн зөвлөмж: Агуулахын бүртгэл хөтөлж, жолоочийн тооцооны хуудас, анхан шатны баримтыг заврын дагуу хөтлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалинтай холбоотой | 1 | 3,452.9 | 1 | 3,452.9 | - | - | - | - | - | - | - | - |
| Цалинтай холбоотой | 2 | 3,299.2 | | | 2 | 3,299.2 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **6,752.1** | 1 | 3,452.9 | 2 | 3,299.2 | **-** | **-** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Анхан шатны баримттай холбоотой | 1 | 0.0 | - | - | - | - | 1 | 0.0 |
| **Дүн** | **1** | **0.0** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **0.0** |

**Тав. <u>Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл</u>**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР